

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLIV (543)

Улаанбаатар

2020

Ф.М.ДОСТОЕВСКИЙН ЗОХИОЛ ДАХ ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ САНААНЫ ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТУХАЙ

Н.Хасбагана

Ф.М.Достоевскийн зохиолын баатрын дүр бүхэнд түүний философийн үзэл санаа нэвт шингэсэн байдаг. Нийгмийн хүнд хэцүү орчинд түний философийн үзэл санаа аажмаар бүрэлдэж христийн шашнаас эх үүсэлтэй наманчлал гэмшил, ариусал, ариун цагаан сэтгэлийн хүчний итгэмжлэл. Оросын шашны үзэл санааг бий болгох гэсэн эрэлхийлэл чармайлгатай уусан нэгдсэн байна.

Түлхүүр үг: *Ф.М.Достоевский, философийн үзэл санаа, Христийн шашина, бурханлаг хувь заяа.*

XIX зууны Оросын алдарт зохиолч Ф.М.Достоевский (1821-1881) нь Оросын уран зохиол, философи хоёрт маш их нөлөө үзүүлсэн сэтгэгч юм. Түүний философийн үзэл санаа нь Оросын ард түмний оюун санааны байдлыг гүн гүнзгий ойлгоход тусалдаг бөгөөд уншигч, сэтгэгчдийг өнөө ч татсаар байгаа билээ. Хэдийгээр Ф.М.Достоевский нь мэргэжлийн философич биш боловч түүний бүтгэлүүдийн баатруудын дурд философийн гүн гүнзгий санаа нэвт шингэсэн байдаг. Өөрөөр хэлбэл түүний зохиолын баатруудын бодол нь зохиолчийн итгэл найдвар, хүсэл эрмэлзлийг тод илэрхийлдэг гэсэн үг юм. Ф.М.Достоевский бүтээлдээ антропологи, шашны гүн ухаан, ёс зүй, түүхийн философийн асуудлуудыг хөндсөн байна. Тэрбээр бодлын цар хүрээ, нөлөө нь хүмүүсийг үргэлж гайхшуулсаар ирсэн ба өнөө ч тэр байдлаа алдаагүй ажээ. Зохиолчийн философийн санаа орчлон ертөнц болон түүн дотроос хүний талаар маш их бодлыг шингэсэн байдаг. Тиймээс түүний зохиолууд зөвхөн уран сайхны бүтээлээс хальж ертөнцийг үзэх үзэл бодлын эргэцүүллийг байнга тавьдаг онцлогтой.

Шоронд хоригдож, цөллөгт явсан зэрэг нь Ф.М.Достоевскийн үзэл санаанд өөрчлөлт гарахад хүргэжээ. Тэрбээр Оросын ард түмэнд тулган буй социализмын үзэл санааны зохиомол байдал, түүний хор хөнөөлийг ойлгож байсны хувьд жинхэнэ орос үндэстний шашны сургаалыг бий болгохыг эрэлхийлэн тэмүүлж байв. Учир нь Ф.М.Достоевскийн хийсэн бүх эрэл хайгуулын үндэс нь шашин байсан билээ.

Ф.М.Достоевскийн философийн сэтгэлгээ нь шашнаас үүдэлтэй тул бүх ухамсар нь Оросын ард түмний бурханлаг хувь заяанд гүн итгэдэг нь нэвт шингэсэн байв. Энэ бол хүн төрөлхтөн, түүх, ёс суртахууны асуудлыг шашны агуулгаар дүүргэсэн Ф.М.Достоевскийн бүтээлийн хүчтэй тал юм. Эдгээр асуудал Ф.М.Достоевскийн “Гэм зэм” роман дахь Миколка, “Солиог” роман дахь хунтайж Мышкин, “Карамазовын хөвгүүд” роман дахь Зосимийн аав зэрэг дүрийг бүтээхэд тулхэц өгчээ. Ф.М.Достоевскийн зүрх сэтгэл, ухамсарт соёлын асуудал үргэлж гүнзгий байрладаг бөгөөд Христийн шашны үзэл санаа, дэлхийн соёл иргэншлийн ололт амжилтыг хослуулах боломжтой гэдэгт тэр итгэдэг байв. Тэрээр соёлоос дайсагнал, дургүйцлийг хэзээ ч мэдэрч байгаагүй аж.

Ф.М.Достоевскийн сэтгэлгээ нь шашны ертөнцийг үзэх, түүхэн үйл явцын талаарх ойлголтыг илэрхийлдэг. Түүний гол үзэл санаа нь Оросын ард түмэн болон Оросын соёл

дахь үнэн алдартны мессианизмд итгэх итгэл байв. Хүний эрх чөлөө Достоевскийн хувьд ариун зүйл мэт санагдах боловч хэн ч үүнд халдахыг зүрхэлдэггүй. Ф.М.Достоевский бол эрх чөлөө, албадлагын тухай санааны номлолыг тайлбарлах диалектик хандлагаараа ялгагдана. Үүний тод жишээ нь диалектикийн аймшигт гэрэлтүүлэг болох Ставрогин болон Кирилловын дүр юм. Мөн түүний үл гүйцэлдэх санаанууд нь өөртөө оновчтой санааны философийн тайлбарыг агуулдаг. Тиймээс орчлон ертөнц болон хүн төрөлхтний өмнө хийсэн гэм нүглээ цагаатгах санааны ач холбогдлыг онцолж байв.

Ф.М.Достоевскийн бүтээл нь түүний зохиолч, сэтгэгч болохын хувьд гүн гүнзгий бүтээлч сэтгэлгээг илтгэнэ. Хүний ахуйн асуудал, нийгмийн ёс суртахууны үндэс, түүхийн философийг тэрбээр бүтээлүүддээ үнэн алдартны үзлийн үүднээс маш гүн гүнзгий авч үзжээ. Ихэнх судлаач Ф.М.Достоевский зохиолч, сэтгэгчийн хувьд Оросын философийн сэтгэлгээний хөгжилд маш их нөлөө үзүүлснийг тэмдэглэдэг. Тухайлбал, тэрбээр Оросын үнэн алдартны соёлын асуудал, Оросын шашны ухамсын мөн чанар, түүний Оросын ард түмний хөгжилд гүйцэтгэсэн үүрэг зэргийг гүн гүнзгий авч үзсэн нь онцгой чухал юм.

Христийн шашны үзэл санаа түүний алдартай “Гэм, зэм” романд хамгийн хурц тод туссан байдаг. Роман дахь гол санаа нь энгийн бөгөөд тодорхой. Энэ санаа нь Хуучин Гэрээний “Бүү хөнөө” гэдэг зургаа дахь гэрээслэлийг тусгасан болно. Гэсэн хэдий ч зохиолч энэ үнэнийг тунхаглаад зогсохгүй хүн гэгч олон эрүүгийн гэмт хэрэг үйлдэхийн хажуугаар цэвэр ариун сэтгэлтэй байх боломжгүй гэдгийг нотлохыг хичээсэн байна. Ф.М.Достоевский “Гэм зэм” романдаа хүмүүнлэг бус, христийн шашны эсрэг онолыг няцааж, түүх нь “хүчтэй” хүмүүсийн хүсэл зоригоор хөдөлдөгтгүй, хүмүүс “оюун санааны хуурмаг байдлыг” дагах бус харин зүрх сэтгэлийнхээ дуудлагаар амьдрах ёстой болдог оюун ухааны төгс төгөлдөр чанараар хөдөлдөг гэж нотолсон байдаг. Тэрчлэн “Карамазовын хөвгүүд” романыхаа сүүлчийн дэвтэрт ч энэхүү наманчлалын сэтгэлээр ханасан байдаг. Ер нь Ф.М.Достоевский хүнийг наманчлал, ариусгалд уриалж, нийгмийн асуудлын эх сурвалж, эмх замбараагүй байдал, өнөөг хүртэл үргэлжлэх буюу гарч буй явдлыг урьдчилан харж байна гэж дүгнэж болно.

Ф.М.Достоевскийн философийн өвийн тухай авч үзвэл түүний үзэл санааны талаар олон тайлбар байдаг. Учир нь тэрбээр сэтгэгчийн хувьд олон талтай, зөрчилтэй. Нөгөөтэйгүүр түүний зохиол бүтээлийг бүрэн судлаагүй байгаа билээ. Түүний хувьд хүмүүнлэг хүний хувьд хүн төрөлхтний ёс суртахууны үзэл санаа хамгийн түрүүнд оршдог бөгөөд зохиол бүтээлд нь хөршөө хайрлах хайр бүхнээс дээгүүр тавигддаг.

Эцэст нь хэлэхэд, түүний философийн өвийн утга гэж үзэж болох түүний үгийг хэлэхийг хүсэж байна. “Амьдралын хором бүр, хором мөч бүхэнд хүн ерөөлтэй байх ёстой ...Яахав, зайлшгүй байх ёстой! Үүнийг цэгцлэх нь тухайн хүний өөрийнх нь үүрэг юм. Энэ хуулийг нуссан боловч заавал бий.“

Философи нь нэг үндэсний соёлын харьцангуй хожуу хэлбэртэй боловч түүний байрууд нь үндэсний түүхийн гүнд оршдог. Гэсэн хэдий ч урьдчилсан нөхцөлүүд, тэдгээрийн дагуу хүмүүсийн түүхэн ухамсыг илэрхийлж байгаа нь өөрөө үзэгдэл биш юм. Энэ үзэгдэл нь шинж чанар эсвэл түүний агуулгад нийцсэн хэлбэрийг олж авснаар гарч ирдэг. Хэрэв энэ шалгуураар үзвэл Орос улсад философи нь XIX зууны хоёрдугаар хагаст эхэлдэг гэж үзэж болно. Чухам энэ үе түүхэнд тодорч харагддаг. Учир нь энэ л цаг үед Ф.М.Достоевский, Л.Н.Толстой, В.Л.Соловьев, Н.Я.Бердяев нар туурвиж байсан юм. Тэд бүтээл, туурвилаараа бүх дэлхийд таниулж, дэлхийн соёлд хувь нэмэр оруулсан дуу хоолой болж чадсан байна.

Сонгодог урлагийн өв рүү хандах нь үргэлж ач холбогдолтой бөгөөд тэдний бүтээл олон зууны туршид амьдарсаар ирсэн тул цаг хугацааны үл баригдам гүйдэл ч тэднийг хуучруулдаггүй. Ийм бүтээлийн амьдрах чадварын нууц нь тэдгээрт тавьсан асуултууд үе бүхэнд өөр өөрөөр шийдэгддэгт оршино. Академич М.Б.Храпченко тэмдэглэхдээ “...утга

зохиолын бүтээлд илэрхийлэгдэж буй өөр өөр дэвсгэр хөг, түүний дүрийн нэгтгэн дүгнэлтийн янз бүрийн тал нь онд ондоо эрин үетэй зохицон нийцдэг. Цаг хугацаа өнгөрөх хэрээр түүхэн эрин үе, нэг үеийнхэн өөрчлөгдөх хэрээр бүтээлд агуулагдсан хөг аялгуу байнга дахин онцлогдож: заримдаа чанга сонсогдож байсан нь чимээгүй болж, бусад нь харин эсрэгээрээ урагш түлхэгдэн гарч ирдэг” гэж тэмдэглэсэн байдал. Ийм учраас Ф.М.Достоевскийн тухай ойлголт үнэлэлт нь зөрчил маргаантай байсаар ирсэн ба түүний философийн үзэл санаа, урлагийн арга барил нь хүн төрөлхтний ховор нандин соёлын өв болж үнэлэгдэж байгаа билээ

Resume

Dostoevsky's every character in the novel is absorbed with the philosophical ideas. In the midst of a difficult life, his philosophical ideas were gradually formed from the Christian religion concepts, such as atonement, purity and faith in the power of pure heart. He made efforts to create a Russian religious ideology.

Ном зүй:

- Созина, Е.К.** *Творчество Ф.М.Достоевского в русской философско-критической мысли рубежа XIX начала XX веков.* Ф.М.Достоевский и национальная культура. Челябинск, 1996. - Вып. 2. стр.163-247.
- Терлецкий А.Д.** 1994. *Ф.М. Достоевский и философская критика рубежа XIX начала XX веков.* Симферополь.
- Kravchenko M.** 1969. *Dostoevsky and Psychologists.* Amsterdam.
- Бяржайте Д.Ю.** 1992. *Творчество Ф.М.Достоевского в оценках русской литературной критики XIX начала XX в.: Автoref. дисс.канд. фил. наук.*
- Гессен С.И.** 1990. *Трагедия добра в “Братьях Карамазовых” Достоевского.* О Достоевском. Творчество Достоевского в русской мысли.